



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ
ЗАВХАН АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

212600 Улаастай, Завхан аймаг
Утас/факс: 7046-37-02
www.inspection.gov.mn

2017. 07. 06 № 07-07-027/14

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН БҮРЭН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРГААНД

Барилгын төлөв байдлын тухай.

Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн захиргаанаас аймгийн МХГ-т гаргасан хүсэлтийн дагуу тус сургуулийн Спорт заалын барилгын төлөв байдал, Барилгын тухай хуулийн хэрэгжилтэд Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Ж.Цэдэн-Иш 2017 оны 07-р сарын 03-ний өдөр шалгалт хийлээ. Уг барилга Спорт заалын зориулалтаар баригдаж 1979 онд ашиглалтад орсон, энэ үеэс хойш барилгын үндсэн хийцүүдэд их засвар хийгдээгүй, урсгал засвар хийгдэж ирсэн байна. Барилгын үндсэн хийцүүд: суурь-цутгамал бетон, хана-дүнз, хучилт-мод, дээвэр- төмөр.

Шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ.

Барилгын төмөр дээвэрт ашиглалтад орсон үеэс хойш их засвар хийгдээгүйгээс дусаал гоожиж таазны шавардлага, өнгөлгөө зарим хэсэгт хөндийрсөн, ховхорч унасан, шарласан, модон дам нуруу бамбай хотойж өмхрөн даацын чадвараа алдаж байгаа, барилгын шал хөдөлгөөнтэй, барилгын шаланд мөөгөнцөр үүсч эрүүл ахуйн шаардлага хангахгүй байдал үүссэн, дотор халаалтын систем байхгүй, цахилгааны монтажид гэмтэл үүссэн, цонх хаалга гажсан, цонхны шил хагарч цуурсан, гялгар цаасаар таглаж хадсан, дулааны алдагдал ихтэй, гадна дүнзэн хана нийтдээ зүүн тийшээ хазайсан, барилгын сууринд хагаралтууд гарсан, дээврийн ус зайлцуулах бетон хаяавч зарим хэсэгт тасарч байхгүй болсон, шороонд дарагдсан зэрэг нөхцөл байдлууд тогтоогдлоо.

Дээрхи байдлуудаас үндэслэн ДҮГНЭХ нь:

1. Цэцэн-уул сумын бүрэн дунд сургуулийн Спорт заалын барилгад үүссэн эвдрэл гэмтлүүд болон одоогийн төлөв байдал нь "барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх, тогтвортой байх" гэсэн Барилгын тухай хуулийн 11-р зүйлийн

11.1.1 заалтын болон Барилга байгууламжийн засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД13-04-03-ын 2.4, 2.5 заалтын шаардлага хангахгүй байна.

2. Цаашид барилгын үндсэн хийцүүдэд барилгын норм дүрэмд заагдсан хугацаанд их ба урсгал засвар хийж ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангуулах, барилгын ашиглалтын хугацааг уртасгах, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ *Онбум* Ж.ЦЭДЭН-ИШ